

13-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Эрхэм зорилго

- ✓ Хамт олны тасралтгүй хөгжлийг
- ✓ Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшилцөх

ДЭМЖИНЭ

Алсын хараа

Хүүхдэд ээлтэй, хүнлэг чадварлаг хамт олныг бүрдүүлж эрүүл, аюулгүй таатай орчинд зөв Монгол хүүхдийг хөгжүүлнэ.

Үнэт зүйл

- ✓ Ёс зүй
- ✓ Хамтын ажиллагаа
- ✓ Ур чадвар
- ✓ Аюулгүй орчин
- ✓ Эцэг эх
- ✓ Хүүхэд

Бидний уриа

Хамт олноороо суралцагч байж
Хүүхэд нэг бүрийг хөгжүүлнэ.

Анги зохион байгуулалт


Бага
Дунд
Ахлах
Бэлтгэл

Өдрийн дэглэм

Тухайн бүлгийн хүүхдийн онцлог, улирал цаг уур, нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөх боломжтой

Хамт олны соёл

Хүн бүр ёс зүйн зөв хандлагатай, багаар хамтарч, цагийг баримтлан үр бүтээлтэй, хүүхдийн бүтээлч үйлийг дэмжин хөгжүүлэн ажиллана.



Материаллаг орчин

- Хүүхэд ганцаар болон бүлгээр, багаар ажиллах боломжтой.
- Сонирхолыг татахуйц
- Хэрэглэхэд ойр хялбар, хувирган ашиглах боломжтой.
- Тоглонгоо суралцах хэрэгцээг хангасан байна.
- Сонголтоор ажиллах боломжтой.

Үйлийн орчин

- Бодит үйл явцад оролцох
- Хөдөлгөөний хэрэгцээг хангасан.
- Олон талт туршлага хуриимтуулхуйц
- Үйлийн эзэн идэвхтэй харилцагч байх.
- Хангалттай цаг хугацаатай байх.

Сэтгэл зүйн орчин

- Элдэг дотно харилцааг бүрдүүлсэн.
- Хүүхдэд таатай, хайр халамжийг мэдрүүлхүйц.
- Хүүхдэд баяр баясгалан мэдрүүлхүйц
- Чөлөөтэй асуулт тавьж харилцах боломжтой.



Хүүхэд чөлөөтэй тоглох үйлийг дэмжсэн, эрэл хайгуул хийхэд өдөөсөн суралцахуйн хөгжлийг дэмжсэн, туршилт хийх, энгийн хөдөлмөр хийх, эрүүл аюулгүй орчин бүрдсэн байна.



Дотоод орчин нь осол аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, хөдөлгөөн тоглох үйлийг дэмжсэн, хүүхдийн цогц хөгжлийг дэмжсэн, харилцаа сэтгэн бodoх болон суралцаж арга барил, бүтээлч үйлийг дэмжсэн.

Багшийн үүрэг оролцоо

Багш нь хүүхдийн төлөө гэсэн сэтгэлтэй, тэдэнд хайртай, хүлээцтэй байхын дээр хүүхэд бүр харилцан адилгүй, давуу сул талтай, өөрийн гэсэн зан ааштай гэдгийг хүлээн зөвшөөрч тэдэнд тохирсон эзлтэй, үйл гүйцэтгэх чөлөөтэй орчинг бүрдүүлж хүүхдийн тоглох явцад бүтээлч үлийг дэмжин өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөн бодит баримтад тулгуурлан үнэлж сургалтын агуулга, арга зүйгээ

Туслах багшийн үүрэг оролцоо

Багш нь хүүхдийн төлөө гэсэн сэтгэлтэй, тэдэнд хайртай, хүлээцтэй байхын дээр хүүхэд бүр харилцан адилгүй, давуу сул талтай, өөрийн гэсэн зан ааштай гэдгийг хүлээн зөвшөөрч тэдэнд тохирсон эзлтэй, эрүүл орчинг бүрдүүлж хүүхдийн тоглох явцад бүтээлч үлийг дэмжих ажиллана.

Эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо

Хүүхдээ бусдаас ялгаатай зан ааш, онцлог, аеъяас чадвартай гэдгийг мэдрэх, хүүхдээ анхааралтай сонсож, ярилцах, тэдэнд зөв улгэрлэх, багштай хамтарч хувийн хавтас бүрдүүлж, хүүхдийн хөгжилд бодит хувь нэмэр оруулна.



Хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээ

Сургалтын сайжруулсан хөтөлбөр дахь чадамжаар ажиглалтын тэмдэглэл, хувийн хавтас, хүүхдийн бүтээл, тулгуурлан намар, хавар үнэлнэ. Үнэлгээ нь хүүхдийн цогц хөгжлийг хамарсан бодит баримтад тулгуурласан байна. Үнэлгээнд тулгуурлаж сургалтын агуулга, арга зүйгээ боловсронгуй болгож, эцэг эх асран хамгаалагчид хүүхдийн хөгжлийн төлөвшлийн талаар мэдээлэл өгнө.



ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИЛГО

2024-2025 оны хичээлийн жил

ЗОРИЛГО

ЭНЭ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД СУРГАЛТЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭЛБЭРИЙГ АШИГЛАН ХҮҮХЭД НЭГ БУРИЙН ОНЦЛОГ ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ ХАРГАЛЗАН ДЭМЖИЖ ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИЙН ҮҮРЭГ ОРОЛЦОOG НЭМЭГДҮҮЛЭН ЧАДВАРЛАГ БАГШ, НӨХӨРСӨГ ХАМТ ОЛОН -ЫГ БҮРДҮҮЛЭН АЖИЛЛАНА.

Зорилт 1

“Хүүхэд нэг бүр”-ийн онцлог, ялгаатай байдалд тулгуурлан тэдний тэгш оролцоог ханган тасралтгүй сурах хөгжих үйлийг тоглох явцад нь дэмжиж бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх

Зорилт 2

Багш наар мэргэжлийн бүлгээрээ хамтран арга зүй туршлагаа солилицон ажлын байрандаа тасралтгүй хөгжиж олон талт арга хэлбэрийг ашиглан сургалт үйл ажиллагаагаа үр дүнтэй зохион байгуулж арга зүйн сан бүрдүүлэх.

Зорилт 3

“Хүүхдийн хоол хүнс”-ийг эрүүл аюулгүй орчинд бэлтгэн, илчлэг шим тэжээлтэй олон төрлийн халуун хоол хүнсээр үйлчлэх, “Өдөр бүр сүү” арга хэмжээг хэрэгжүүлэх

Зорилт 4

“Эцэг эх”- тэй хамтарч хүүхдүүдийн дунд “Номын богц” аялуулж уншиж ойлгох чадварыг нэмэгдүүлнэ.

Зорилт 5

“Хүн бүр”- ёс зүйн хэм хэмжээ, дүрэм журмыг мөрдөн зөв хандлагатай, үр бүтээлтэйгээр цагийг баримтлан багаар хамтарч ажиллах

Зорилт 6

Хүүхэд хамгаалал, эрүүл аюулгүй байдал-Нэгдүгээрт арга хэмжээний хүрээнд хүүхэд хамгааллын ажлыг эрчимчүүлж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах